



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга
хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа,
ажлын гүйцэтгэлд нөлөөлж, төсвийн хөрөнгийн үр
нөлөөг бууруулж байна.**

**2021 оны 6 дугаар
сар**



222

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/08

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын эрх үүргийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc \bichig hereg\ tushaal \ 2021.doc

223

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2021 оны
06 дугаар сарын 23-ны өдрийн А/08 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /сая.төгрөг/
1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй 1А хорооллын дэд бүтцийг дуусаагүй барилгад дутуу бүртгэсэн.	03/109 ОРА-2021/90-ШТА-ГА	ОНӨГ	3,599.5
2	8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тооцохдоо суутгалыг дутуу тооцож, холбогдох дансанд шилжүүлээгүй.	04/110 ОРА-2021/90-ШТА-ГА	Аймгийн ЗДТГ	25.2
3	Худалдан авах ажиллагааны тайланд 2%-ийн гүйцэтгэлтэй тайлагнасан, барилгын ажил эхлэх зөвшөөрөл аваагүй, бараа материал татан авсан баримт, фото зураг, гэрээг үндэслэн 15 хувийн гүйцэтгэл баталгаажуулж, санхүүжилт олгосон.	05/111 ОРА-2021/90-ШТА-ГА	ХББЗА ОНӨААҮГ	409.1
4	25 төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэсэн.	06/112 ОРА-2021/90-ШТА-ГА	ХББЗА ОНӨААТҮГ	
Нийт дүн				4,033.8

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7
БҮЛЭГ 1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг холбогдох хууль, журамд нийцүүлэхгүй баталсаар байгаа нь хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих, чанаргүй гүйцэтгэх эрсдэл үүсгэсээр байна.	9
<i>А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж буй ч төлөвлөлийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.</i>	9
<i>А.2 Төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэхгүй баталж байгаа нь хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих, чанаргүй гүйцэтгэх эрсдэл үүсгэж байна.</i>	11
БҮЛЭГ 2. Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэлд нөлөөлж, төсвийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж байна.	13
<i>Б.1 Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа олон хоногоор хоцорч, үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлага үүссэн байна.</i>	13
<i>Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, өмнөх оны алдаа давтагдсаар байна.</i>	14
<i>Б.3 Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.</i>	17
<i>Б.4. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоогүй байна.</i>	19
ДҮГНЭЛТ:	21
Холбогдох байгууллагын санал:	23
Саналд өгсөн тайлбар:	23

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СГСГЗ	Сэлэнгэ голын сав газрын захиргаа
СХЗХ	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УДХТ	Ус, дулаан хуваарилах төв
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХББЗА ОНӨААТҮГ	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШША	Шүүхийн шинжилгээний алба
ЭШУТП ОНӨААТГ	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Батлагдсан төсөв	7
Хүснэгт 2	Он дамжин хэрэгжих ТАХ-ний гүйцэтгэл	17
Хүснэгт 3	ТЕЗ-ийн дуусаагүй барилга дансны судалгаа	18

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2019-2020 оны баталсан ТАХ	6
Дүрслэл 2	Хөрөнгө оруулалтын төрөл	8

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; • Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	Аудитын хязгаарлалт үүсээгүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000, тэдгээрт нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох нар гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2021 оны 06 дугаар сарын 16-нд аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Хүндрэл бэрхшээл


Халдварын цар тахал /ковид 19/-тай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, албад, албан тушаалтан, ТАХ-г хэрэгжүүлэгч ААНБ-тай харилцахад цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2019 оны 11 сарын 29-ний 15/03, 15/04 дүгээр тогтоолоор 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 245 ТАХ, 167 төсөл, хөтөлбөр, нийт 412 ТАХ-нд 28,789.9 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих 35 ТАХ-нд 1,941.9 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 17 ТАХ-нд 1,219.2 сая төгрөг, орон нутгийн Эрдэнэт сангийн хөрөнгөөр хэрэгжих 42 ТАХ-нд 6,077.6 сая төгрөгийг тус тус баталсан байна. Үүнээс 16,560.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 89 ТАХ нь өмнөх оноос дамжин хэрэгжсэн байна.

2019, 2020 онд баталсан ТАХ-г харьцуулбал ТАХ-ний тоо 20-оор буурч, санхүүжих дүн 19,614.2 сая төгрөгөөр өсжээ.

Дүрслэл 1 2019-2020 оны баталсан ТАХ /тоо, сая төгрөг/



Шинээр хэрэгжих 417 ТАХ-ээс 161 ТАХ-нд худалдан авах ажиллагаа шаардлагагүй, 256 ТАХ-нд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Зураг төсөв хүлээгдсэн, техникийн тодорхойлолтгүй, амжилтгүй болсон 5 ТАХ-ний худалдан авах ажиллагаа 2020 онд хэрэгжээгүй байна.

2020 онд шинээр хэрэгжсэн 41,474.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 198, өмнөх оны дуусаагүй 7,061.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 24 ТАХ-нд аймгийн ЗДТГ болон ХББЗА ОНӨААТҮГ хяналт хэрэгжүүлсэн байна. Дээрх ТАХ-ээс 2020 онд 18,944.0 сая төгрөгийн 193 ТАХ хэрэгжиж дууссан ба 29,591.7 сая төгрөгийн 29 ТАХ дуусаагүй байна.

БҮЛЭГ 1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг холбогдох хууль, журамд нийцүүлэхгүй баталсаар байгаа нь хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих, чанаргүй гүйцэтгэх эрсдэл үүсгэсээр байна.

А.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж буй ч төлөвлөлийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ баталсаар байна.

А.1.1 Батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2020 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 11 сарын 29-ний 15/03, 15/04 дүгээр тогтоолоор 2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 245 ТАХ, 167 төсөл, хөтөлбөр, нийт 412 ТАХ-нд 28,789.9 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих 35 ТАХ-нд 1,941.9 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 17 ТАХ-нд 1,219.2 сая төгрөг, орон нутгийн Эрдэнэт сангийн хөрөнгөөр хэрэгжих 42 ТАХ-нд 6,077.6 сая төгрөгийг тус тус баталсан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1		Батлагдсан төсөв		/сая төгрөг/			
д/д	Хөрөнгө оруулалтын төрөл	Анх баталсан /2019.11.29/		Тодотгон баталсан /2020.11.30/		Зөрүү	
		төсөл, арга хэмжээний тоо	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	санхүүжих дүн /сая.төг/	төсөл, арга хэмжээний тоо	санхүүжих дүн /сая.төг/
1	Шинээр хэрэгжих	169	13,600.5	203	17,264.5	34	3,664.0
2	шилжих үлдэгдлээс	76	7,675.9	58	7,665.0	-18	- 10.9
3	байгаль хамгаалах арга хэмжээ	35	1,941.9	35	1,941.9	0	-
4	автозамын сан	17	1,219.2	17	1,219.2	0	-
5	төсөл хөтөлбөр	167	7,513.5	179	8,265.6	12	752.1
6	эрдэнэт сан	42	6,077.6	44	18,549.6	2	12,472.0
Нийт дүн		506	38,028.6	536	54,905.8	30	16,877.2

Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн 6 удаагийн хуралдаанаар ТАХ-ний нэр өөрчилж, зарим ТАХ-г шилжүүлж тодотгосон байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолоор 22 ТАХ-г хасаж, 54 ТАХ-г шинээр нэмж, 2 ТАХ-ний дүнг нэмэгдүүлж, 5 ТАХ-ний дүнг бууруулж,
2. 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 16 тогтоолоор 9 ТАХ-ний нэрийг өөрчилж 8 ТАХ болгож,
3. 2020 оны 06 дугаар сарын 27-ны 17 дугаар тогтоолоор 1 ТАХ-ний нэр өөрчилж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх 1 ТАХ-г баталж,
4. 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тогтоолоор 1 ТАХ-г хасаж, 7 ТАХ-ний дүнг бууруулж, 2 ТАХ-ний дүнг нэмэгдүүлсэн байна.

2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд нь Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдсан байна.

2020 онд хэрэгжих 536 ТАХ-ээс 200 төсөл хөтөлбөр, он дамжих хэрэгжиж буй 80 ТАХ, шинээр эхлэх 256 ТАХ-г төлөвлөсөн ба үүний 9 буюу 3.5 хувь нь барилга байгууламж, 16 буюу 6.3 хувь нь инженерийн шугам сүлжээ, 111 буюу 43.4 хувь нь

барилга, тохижилтод, 12 буюу 4.7 хувь нь гэрэлтүүлэг, цахилгаан, 37 буюу 14.5 хувь нь авто зам, 63 буюу 24.6 хувь нь тоног төхөөрөмж, 8 буюу 3.1 хувь нь зураг төсөв, зөвлөх үйлчилгээнд төлөвлөсөн байна. Үүнийг дүрслэлээр үзүүлбэл:

Дүрслэл 2 Хөрөнгө оруулалтын төрөл /тоо, хувь/



А.1.2 Жагсаалтад батлагдсан ТАХ-г төсвийн шууд захирагчдын саналд үндэслэсэн байна

2020 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээг төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулсан байна. Харин 135 ТАХ-ний саналын хэрэгцээ шаардлагыг хэлэлцэж хойшлуулсан байна.

А.1.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлдэг боловч аймгийн ИТХ төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхгүй байсаар байна.

Орон нутгийн төсвийн төсөлд ирүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нэгтгэн эрэмбэлж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, саналыг боловсруулсан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2020 оны орон нутгийн төсвийн төслийн үр ашгийг сайжруулж, зардал бууруулахаар оруулсан саналыг авч хэлэлцэхгүйгээр зарим ТАХ-г баталж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- А1001 замын ажилтай уялдуулан үерийн суваг хийх /100 айл зах/ 153.6 сая төгрөг,
- 6-р хорооллын 9-р байрны урд амралт чөлөөт цагийн талбай, автомашины зогсоол байгуулах 95.0 сая төгрөг,
- Статистикийн хэлтсийн /111 тоот/ өрөөний засвар 2.0 сая төгрөг,
- аймгийн ЗДТГ-ын бэлэг дурсгалын зардал 148.5 сая төгрөг,
- аймгийн ИТХ-ын бэлэг дурсгалын зардал 49.5 сая төгрөг.

Мөн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтад Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн зарчимд нийцэхгүй, орон нутгийн төсөвт хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын албан хэрэгцээнд автомашин, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламж худалдан авах, барих ажилд 729.7 сая төгрөгийн төсөв баталж, хэрэгжүүлжээ. Үүнд:

- СХЗХ-т тоног төхөөрөмж худалдан авахад 11.3 сая төгрөг,
- ШШАлбанд зургийн аппарат авахад 1.8 сая төгрөг,
- УБХ-т хувилагч авахад 11.6 сая төгрөг,

- Татварын хэлтэст шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 55.0 сая төгрөг,
- Тагнуулын газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөг,
- БОАЖГ, СГСГЗ-ны захиргааны байр барихад шаардлагатай ИШС барих 200.0 сая төгрөг,
- Шүүхийн шинжилгээний албанд байр худалдан авах 350.0 сая төгрөг,

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “Монгол Улсын Засгийн газар /цаашид “Засгийн газар” гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасны дагуу орон нутгийн төсвийг үр ашигтай төлөвлөх дүгнэлт, санал зөвлөмжийг жил бүр аймгийн ИТХ-д оруулсаар ирсэн.

Орон нутгийн төсвөө батлахдаа төрийн аудитын байгууллагын зардал бууруулахаар хүргүүлсэн зарим ТАХ-г баталснаар хөрөнгө оруулалтын ажлын явц удаашрах, худалдан авах ажиллагаа хойшлох, улмаар ажлын чанарт нөлөөлж байна. Иймд зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй ТАХ-г жагсаалтад тусгахгүй, батлахгүй байх шаардлагатай байна.

А.2 Төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэхгүй баталж байгаа нь хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих, чанаргүй гүйцэтгэх эрсдэл үүсгэж байна.

А.2.1 Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөлд үндэслэн боловсруулсан байна.

Геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл авах шаардлагатай 9 ТАХ байгаа бөгөөд газрын зөвшөөрлийг жагсаалт батлахаас өмнө олгосон байна. Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлдэг байна.

А.2.2 2019 оноос он дамжин хэрэгжиж буй 1 ТАХ-ний зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй байхад ажлаа эхэлсэн байна.

Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм”-д зааснаар 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ээс барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжид хамаарах 5, бага төвөгшилтэй барилга байгууламжид хамаарах 4 барилгын ажил байгаа бөгөөд эдгээрээс 5-д нь зураг, төсвийн магадлал хийлгэх шаардлагагүй, 4-т нь зураг, төсвийн магадлал хийлгэж баталгаажуулах ажлууд байна.

Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно” гэж заасан байтал “Цэцэрлэгт хүрээлэн”-гийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэгч Сокол ХХК зөрчиж, суурийн нүх ухах ажлыг эхлүүлсэн байна. Тухайн ажлыг түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр болсон хэдий ч зураг, төсвийг одоог болтол магадлалаар баталгаажуулаагүй байна.

А.2.3 Шинээр хэрэгжүүлэх 7 ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад аймгийн ИТХ-аар баталжээ.

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 536 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв шаардахгүй 290 ТАХ, өмнөх оноос шилжин хэрэгжих 71 ТАХ, зураг төсөвтэй хэрэгжих 175 ТАХ байх ба 7 ТАХ-г зураг төсөлгүй баталсан байна.Үүнд:

- 11-р хорооллын А,В хэсэгт ИШС шинээр барих,
- БОАЖГ, СГСГЗ-ны захиргааны байр барихад шаардлагатай ИШС барих,
- “Миний гудамж-бидний гэр” төслийн хүрээнд гэр хороололд баригдсан цэвэр, бохир усны төв шугамаас салбар шугам сүлжээ татах /Зүүн дэнж, Булаг, Уртын гол, Рашаант, Баянбулаг, Наран, Баянцагаан, Цагаанчулуут/,
- Залуучуудын экстрем спортын талбай байгуулах,
- Жаргалант сумын ундны усны эх үүсвэр хамгаалах харуулын цэгийн 2 суурийн станц, гэрэлтүүлэг хийх,
- ЭШУТПарк ОНӨААТГ-ын үйлдвэрлэлийн барилга.
- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн захиргааны байр барих.

Өмнөх онд баталсан 3 ТАХ-ний төсөвт өртгийг 1,354.7 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Тухайлбал,

- Жаргалант суманд уурын зуух барих ажлын төсөвт өртөг 2019 онд 2,500.0 сая төгрөг, **2020 онд 1,250.0 сая төгрөг,**
- Булаг багт Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих ажлын төсөвт өртөг 2019 онд 1,234.4 сая төгрөг, **2020 онд 43.0 сая төгрөг,**
- Барилгачдын талбайн дэргэд нийтийн бие засах газар барих ажлын төсөвт өртөг 2019 онд 25.0 сая төгрөг, **2020 онд 61.7 сая төгрөг.**

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

А.2.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 5 ТАХ-нд 290.5 сая төгрөгийг төлөвлөж, баталжээ.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн нийт 37,331.1 сая төгрөгийн 256 ТАХ-ний 72.3 хувийг барилга байгууламж, их засварын ажилд, 24.6 хувийг их засварын ажилд, 3.1 хувийг зөвлөх үйлчилгээнд төлөвлөсөн байна. Эдгээр ТАХ-ээс хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 5 ТАХ-нд 290.5 сая төгрөг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн автомашины урсгал засварын зардал 6.0 сая төгрөг,
- Олон нийтийн цагдаагийн хувцас хэрэглэл худалдан авах 64.0 сая төгрөг,
- Аймгийн ИТХ-ын бэлэг дурсгал худалдан авах 49.5 сая төгрөг,
- Аймгийн бэлэг дурсгал худалдан авах 148.5 сая төгрөг,
- Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө бүтээн байгуулалтын тайлан ном, эмхэтгэл хэвлүүлэх зардал 22.5 сая төгрөг.

БҮЛЭГ 2. Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэлд нөлөөлж, төсвийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж байна.

Б.1 Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа олон хоногоор хоцорч, үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлага үүссэн байна.

Б.1.1 ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г төлөвлөсөн хэдий ч зураг төсөвгүйгээс 184 ТАХ 1-232 хоногоор хоцорчээ.

Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 97.7 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 256 ТАХ-ээс 5 ТАХ-ний зураг төсөв хүлээгдэж байгаа ба 251 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнээс цахимаар 228, уламжлалт хэлбэрээр 23 ТАХ-г зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны 2020 оны төлөвлөгөөнд тусгасан хэрэгжилтийн хугацааг 1-232 хоногоор хэтрүүлсэн байна. Тухайлбал:

- Үнэлгээний хороо байгуулах хугацаанаас 1-90 хоног хэтрүүлсэн 2 ТАХ,
- Цахим системд урилга нийтлэх хугацаанаас 1-186 хоног хэтрүүлсэн 139 ТАХ,
- Гэрээ байгуулах хугацаанаас 1-232 хоног хэтрүүлсэн 184 ТАХ,
- Гэрээ дуусгаж, дүгнэх хугацаанаас 2-168 хоног хэтрүүлсэн 122 ТАХ,
- Тендер хүчинтэй байх хугацааг сунгасан 12 ТАХ.

Харин тендер шалгаруулалт 2-6 удаа зохион байгуулсан 74 ТАХ байх ба 6 удаа зохион байгуулсан 2 ТАХ байна.

Тайлант онд гэрээ байгуулсан ТАХ-ээс 128 ТАХ тайлант хугацаандаа хэрэгжиж, 122 ТАХ хугацаа хэтэрч, 6 ТАХ тайлант хугацаанд хэрэгжээгүй байна. Тайлант хугацаанд хэрэгжээгүй ТАХ-ний зураг, төсөл хугацаандаа батлагдаагүй, техникийн тодорхойлолт ирүүлээгүй, худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, гомдол гаргаснаас шалтгаалжээ.

Б.1.2 2020 онд эрх бүхий байгууллагад гаргасан гомдол шийдвэрлэсэн байдал нь үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Орхон аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд баталсан 256 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 10 үнэлгээний хороо байгуулжээ. Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Үнэлгээний хороод Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалаар батлагдаж, 2019 оны нэмэлт өөрчлөлт оруулсан “Бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичиг”-ийг баримтлан боловсруулсан байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Монголын мэдээ сонинд нийтлүүлэн, tender.gov.mn болон erdenet.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангажээ.

Хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалттай холбоотой 7 гомдлыг Сангийн Яаманд гаргасан ба захиалагчийн шийдвэр үндэслэлтэй 3, дахин үнэлгээ хийх 4 гэж шийдвэрлэсэн нь үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Б.1.3 ХАА-ны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Аймгийн ОНӨГ нь Орхон аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр тайлагнаж, erdenet.mn, shilendans.gov.mn болон tender.gov.mn цахим хуудсанд тогтмол мэдээлж хэвшсэн байна.

Орхон аймгийн 2020 оны худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д “Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана” гэж заасны дагуу тухай бүр Сангийн яаманд хүргүүлжээ.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, өмнөх оны алдаа давтагдсаар байна.

Б.2.1 Захиалагчийн хянасан 104 ТАХ-ээс 27 ТАХ буюу 26.0 % -д захиалагчийн хяналт хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлж, 103 ТАХ гэрээний хугацааг хоцроосон байна.

2019 оны дуусаагүй 24, 2020 онд шинээр хэрэгжсэн 512 ТАХ-ээс 29 ТАХ он дамжиж, 5 ТАХ хэрэгжээгүй буюу худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 502 ТАХ бүрэн хэрэгжжээ. 2020 онд 48 ТАХ-ний гэрээний хугацааг сунгасан байна. Гэрээг сунгах үндэслэл, шалтгаан нь тодорхой тусгаагүй байна. Харин аваарын зардлаар аймгийн Засаг дарга 10 удаагийн захирамжаар 1,586.2 сая төгрөгийн 69 ажил баталж, Хотын захирагчийн алба хяналт хэрэгжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 40.2 дах заалт болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд гүйцэтгэгч нь зураг, төслийн дагуу ажил, үйлчилгээг хугацаанд нь буюу чанартай гүйцэтгэхээр заасан байна.

Гэрээ дуусах хугацаандаа хүлээлгэж өгсөн 100 ТАХ, хугацаа хоцроож хүлээлгэж өгсөн 103 ТАХ байх ба гэрээний хугацаа хоцорсон 11 ТАХ-нд нийт 10.6 сая төгрөгийн алданги тооцож суутгасан байна.

2020 оны хөрөнгө оруулалтын хугацаа хэтэрсэн 92 ТАХ-нд алданги тооцохоор байсан ч халдварт цар тахлаас шалтгаалан хил гааль хаагдаж, бараа материалын хомсдол үүссэн зэргийг харгалзан холбогдох байгууллагууд хурлын тэмдэглэлээр баталгаажуулж, тооцоогүй байна.


Аудитын явцад улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 104 ТАХ-ний хэрэгжилтийг тулган баталгаажуулахад гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн дараах ажлууд байна. Үүнд

Улсын төсвийн ТАХ

- Гэр хорооллын дэд бүтэц /Орхон, Баян-Өндөр сум, Баянбулаг, Булаг, Даваат, Наран, Рашаант, Цагаанчулуут баг/ Химон констракшн ХХК – Даваат, Булаг багийн цэвэр ус дамжуулах худаг хөлдсөн байна.
- Залуучуудын ордны барилга /Орхон, Баян-Өндөр сум/ Эрин гүрэн ХХК – Барилгын хана дүүргэлтээр цууралт үүсэж, дээврээс ус гоожсон байна.
- Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг/ Рино инженеринг ХХК - Барилгын хана дүүргэлтээр цууралт үүсэж, бие засах өрөөний дүүжин таазыг бэхлээгүй байна.
- Соёлын төвийн барилга 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Даваат баг/ Хөх тавилан ХХК – Гадна хаяавчны зуурмаг чанаргүйгээс бутарсан, паркет шал суулгалт муугаас хөндийрч хөөсөн, цонхны вакум муугаас цантаж хагарсан,

үүдний хаалганы шил, плита хагарсан, зарим цонхны чигжээс хийгээгүй, агааржуулалтгүй байна.


- Баянбулаг Булаг баг хоорондын авто зам, явган хүний зам, гудамжны тохижилт /Орхон, Баян-Өндөр сум/ Сэлэнгэ есөн эрдэнэ ХХК – Чулуун хавтангуудын чигжээс муугаас суларсан байна.



Орон нутгийн төсвийн ТАХ

- Ханддоржийн гудамжны авто замын өргөтгөл, Өлзий хутгийн наран ХХК – Өргөтгөсөн зам хуучин авто замтай ижил түвшинтэй хийгээгүй, тэгш бус болсон байна.
- Даваат баг, Зураагийн 8-р гудамж, амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Шанхат хүрэн ХХК – хогийн савнууд бэхлээгүй, хиймэл зүлэг бэхлээгүйгээс хуурсан, сандал, саравчны хугарсан, хашааны хаалга алга болсон байна.
- Баянцагаан баг, амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Шанхат хүрэн ХХК – эргэдэг тоглоом эргэхгүй болж, саравчны дээвэр хуурсан, савлуурын хаалга алга болсон байна.
- Их залуу баг, Багийн байрны зүүн талд амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Констант констракшн ХХК – резин будаг хуурсан байна.
- 6-р хорооллын 9-р байрны урд амралт чөлөөт цагийн талбай, автомашины зогсоол байгуулах, Констант констракшн ХХК – Хогийн сав, сандал чанаргүйгээс хугарч, бэхэлгээ муу хийсэн, явган замын хавтангийн чанар хангалтгүйгээс бутарч, хагарсан байна.
- Цагаанчулуут баг, 7-р хороололд амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Тоджаргал ХХК – Хашааны тор урагдаж, 3 тоглоом алга болсон байна.
- Уртбулаг баг, 5-18-р байрны урд тоглоомын талбайг өргөтгөх, Орхон тод од ХХК – сандлын бариул хугарсан байна.
- Баянбулаг баг, Ургацын хэсэгт амралт чөлөөт цагийн талбай байгуулах, Мээжийн савдаг ХХК – сандлын түшлэг хугарч, чийрэгжүүлэлтийн 1 тоног төхөөрөмж, хашааны хаалга алга болсон, сагсны талбай зуурмагийн чанараас шалтгаалан бутарсан байна.
- Их залуу баг, Баруун задгайн 11-р гудамжны зүүн талд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Хөх сэрхийн мандал ХХК – талбайн резин будаг хуурсан, савлуурын бэхэлгээ муу хийсэн байна.
- Дэнж баг, Зүүн дэнж хэсэгт хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Сэмэ ХХК – талбайн резин будаг хуурсан байна
- Говил баг, Хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Шанхат хүрэн ХХК – Талбайн хавтангуудын бэхэлгээ суларч салсан, хогийн сав чанаргүйгээс эвдэрсэн, хаалга алга болсон байна.

- Дэнж багийн Өндөр дэнж 49, Элит 9-ийн А,Б байрны орцны кодтой цоож хийх, Авто мастер ХХК – 6 хаалганаас 2 хаалганы кодтой цоож ажиллахгүй байна.
- 13-р сургуулийн гадна биеийн тамирын талбайг иж бүрэн тохижуулах, Шинжүү ХХК – талбайн резин будаг хуурч, хөл бөмбөгийн талбайн цагаан тэмдэглэгээг сайн бэхлээгүйгээс салсан байна.
- Явган замын ажил хийх, Олз мандал ХХК – Явган замын хавтан, хашлагууд бэхлээгүй, чигжээс хийгээгүй, суурийн нягтруулалт хангалтгүйгээс тэгш бус хийгдсэн байна.
- Наран баг, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Цагаан бүргэд констракшн ХХК – замын хашлаганы бэхэлгээ, чигжээс муугаас суларч, унасан байна.
- Өрхийн эрүүл мэндийн төвийн барьж эхлүүлэх, Шинжүү ХХК – Суурь, блок өрлөгийн залгаагаар цууралт үүссэн, шалны тэгшилгээ сайн хийгээгүй байна.
- УДХТ 1-5-ыг үл хамаарах системд шилжүүлэх, Хөх тавилан ХХК – Тэлэлтийн савны хэмжээг төсөвт заасан хэмжээнээс бага үзүүлэлттэйг суурилуулсан байна.
- Наран баг, 65, 41-р гудамжинд жишиг гудамж тохижуулах, Хөх сэрхийн мандал ХХК - блокоор барьсан 6, төмөр хийцтэй 3, 9 ширхэг хаалга будаагүй, 500 ширхэг улиас болон зүлэгжүүлэлт хийгээгүй байна.
- Гал унтраах, аврах 68-р ангийн автомашины гаражийн өргөтгөл барих, Титэм констракшн ХХК - хаяавчаар дотогшоо ус ордог байна.
- Зэст баг, 1-25-р байрны дэргэд хүүхдийн тоглоомын талбай байгуулах Констант констракшн ХХК - резин будаг хуурсан, дүүжин тоглоомын бэхэлгээ хангалтгүй хийсэн байна.



Аудитын түүвэрт хамруулж, тулган баталгаажуулсан 104 ТАХ-ээс 2 ТАХ 26.0 % -д захиалагчийн хяналт хангалтгүй, үр дүн муутай хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Иймд барилга, байгууламж, дэд бүтцийн ажлуудын ашиглалтын явцад үүсэж буй гомдол, зөрчил нь гүйцэтгэгч байгууллагын чанаргүй, дутуу хийсэнтэй холбоотой бөгөөд алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулах, хангагдахгүй шалтгаан үр дагаврыг судлах, баримт бичгийн бүрдэл хангуулах, ажлын чанар байдалд бүрэн хариуцлага хүлээх хууль, журам, стандартын мэдээлэл, сурталчилгаа хийж байх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ-г чанаргүй, дутуу гүйцэтгэдэг ААНБ-дад хариуцлага тооцуулахаар хуулийн байгууллагад хандан, шийдвэрлүүлж байхыг анхаарах шаардлагатай болсон байна.

Б.2.2 Захиалагч зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээг авч, үр дүнд хүрсэн байна.

Захиалагч болон зохиогчийн хяналт нь Барилгын тухай хуулийн 35, 37, 38.1.8, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтуудын хүрээнд байгуулсан гэрээ, хэлцлийн үндсэн дээр хэрэгжиж байна. Зохиогчийн хяналтыг зураг, төсөв зохиогч иргэн, ААНБ, захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ, түүний харьяа алба, хэлтсүүд хэрэгжүүлсэн байна.

Нийт 267 ТАХ-нд урьдчилсан комисс ажиллаж, үүрэг даалгаврыг саналын хуудсаар өгч баталгаажуулж, биелэлтийг хянуулснаар, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажилласан байна.

ТАХ-ний явцад МХГ, ОБГ, ГХБХБГ, зураг төсөв зохиогч хяналт хэрэгжүүлж, барилгын ажлын талбайн дэвтэрт тэмдэглэл, үйлдэж, хугацаатай үүрэг даалгавар өгснийг техникийн комисс, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс хянаж биелэлтийг хянасан байна.

Б.3 Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Б.3.1 ТАХ-ний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо бүрдсэн хэдий ч өмнөх оны алдаа зөрчил давтагдсаар байгаа нь үе шатны хяналтыг хэрэгжүүлэх инженерүүдийн хариуцлагыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11-д заасны дагуу захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй байдаг. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын 198 ТАХ-нд ХББЗА ОНӨААТҮГ, аваарын зардлаар хэрэгжүүлсэн 69 ТАХ-нд Хотын захирагчийн алба, тоног төхөөрөмж худалдан авах 74 ТАХ-нд ОНӨГ, 259 төсөл хөтөлбөрт аймгийн ЗДТГ захиалагчийн тавих үе шатны болон явцын хяналтыг хэрэгжүүлжээ.

Дээрх байгууллагууд нь ТАХ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээ, хэлцлийг мөрдөн, барилгын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгах, баримт бичгийн бүрдлийг хангуулах, ашиглалтад хүлээн авах үүргийг гүйцэтгэжээ. Илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээг авч, техникийн болон улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, холбогдох баримтаар баталгаажуулсан байна.

Нийт 267 ТАХ-нд урьдчилсан комисс ажиллаж, үүрэг даалгаврыг саналын хуудсаар өгч баталгаажуулж, биелэлтийг хянуулснаар, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажилласан байна. Эдгээрт дуусаагүй 22 ТАХ хамаарахгүй бөгөөд 223 ТАХ-ний урьдчилсан комиссын үүрэг даалгаврын биелэлт хангагдаж, улсын комисс ажиллаж хүлээн авсан байна. Харин 22 ТАХ-ний үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүйгээс он дамжжээ.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралтын ажлын үе шат бүрд тавих хяналт хангалтгүйгээс өмнөх онд гарсан алдаа, зөрчил давтагдаж байгаа хяналтын инженерүүдийн хариуцлагатай холбоотой бөгөөд ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанаргүй гүйцэтгэхэд хүргэж байна. Аудитаар тулган баталгаажуулсан чанаргүй хийгдсэн 25 ТАХ-г дахин гүйцэтгүүлж, хүлээн авах албан шаардлага хүргүүлсэн болно.

Б.3.2 Тухайн жилд батлагдсан санхүүжилтээс барилгын ажил эхлэх зөвшөөрөлгүй 1 ТАХ-г санхүүжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-аар 54,905.8 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэгч байгууллагад 38,649.0 сая төгрөг буюу 70.3 %-ийг олгосон байна.

Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авсан комиссын шийдвэрийн дагуу гэрээг дүгнэж санхүүжилтийг олгосон байна. 39 ТАХ-нд 84.1 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэл, тооцоог үндэслэн олгосон байна.

8 ТАХ-ний санхүүжилтийг тооцохдоо 25.2 сая төгрөгийн суутгалыг дутуу тооцож, холбогдох дансанд шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.2-д “Захиалагч нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 5.2.6-д “Барилгын ажлын зардал, техник эдийн засгийн урьдчилсан судалгаа/цаашид “ТЭЗУС” гэх/, техник эдийн засгийн үндэслэл /цаашид ТЭЗҮ гэх/ зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгааг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд дутуу тооцсон суутгалыг холбогдох дансанд шилжүүлэх албан шаардлагыг хүргүүллээ.

Захиалагч “Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн захиргааны байр барих” ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ 2020 оны 11 сарын 10-ны өдөр батлагдсан байна. Засгийн газрын 2020 оны 11 сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хязгаарлах үйл ажиллагаанд тус үйл ажиллагаа хамаарч, ХББЗА ОНӨААТҮГ-аас 2020 онд ажил эхлэх зөвшөөрөл олгоогүй байна. Ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2021 оны 06 сарын 07-ны өдөр авсан байна.

Худалдан авах ажиллагааны тайланд 2%-ийн гүйцэтгэлтэй тайлагнасан, барилгын ажил эхлэх зөвшөөрөл аваагүй, бараа материал татан авсан баримт, фото зураг, гэрээг үндэслэн 15 хувийн гүйцэтгэлээр баталгаажуулж 409.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.12-т “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно”, БЗА-181/20 гэрээний 1.4-т “Санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан төсвийн хөрөнгө

оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын дагуу гүйцэтгэлээр санхүүжүүлнэ” гэж заалтуудыг зөрчсөн байна.

Иймд барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хууль журмын дагуу үнэн зөв гаргаж алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.4. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоогүй байна.

Б.4.1 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засаг даргын дотоод хяналтыг 2021 онд хийхээр төлөвлөсөн байна.

2020 оны ТАХ-ний хэрэгжилтийг дүгнэвэл 245 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 29 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих болж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 89.4%-аар биелж, өмнөх оны гүйцэтгэлээс 2.1%-аар өсжээ.

Он дамжин хэрэгжих 29 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 2 Он дамжин хэрэгжих ТАХ-ний гүйцэтгэл /тоо, хувь/

Төсөл, арга хэмжээ	2-20%	30-50%	60-80%	90%
Тоо	6	8	10	5
Хувь	20.7	27.6	34.5	17.2

Аливаа ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эрсдэлийг бага гэж тооцон дотоод хяналтыг хийгээгүй байна. Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдэд дотоод хяналт шалгалтыг 2021 оны 9, 10 дугаар сард хийхээр төлөвлөгөө, удирдамжид оруулж аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Б.4.2 2018-2020 онд ашиглалтад орсон 5 ТАХ-г одоо болтол бүрэн хүчин чадлаар ашиглаагүй, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

2019 оны дуусаагүй болон 2020 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга байгууламж, их засварын ажил, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагуудын эзэмшилд шилжүүлж, бүртгэл, тайланд тусгасан байна.

2018-2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 10,960.1 сая төгрөгийн 72 ТАХ байгааг ОНӨГ-ын бүртгэл, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн

мэдэгдэлтэй тулгахад 242.2 сая төгрөгийн 4 ТАХ-г давхар бүртгэснийг залруулж, 2 ТАХ-ний гүйцэтгэлийг 3,599.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Хүснэгт 3 ТЕЗ-ийн дуусаагүй барилга дансны судалгаа /тоо, сая төгрөг/

Хөрөнгө оруулалтын жил	Дуусаагүй барилгад бүртгэлтэй байгаа		Давхар бүртгэснийг залруулсан /2021 онд/		Дутуу бүртгэсэн	
	тоо	Дүн /сая.төгрөг/	тоо	Дүн /сая.төгрөг/	тоо	Дүн /сая.төгрөг/
2017 он	16	4,174.7				
2018 он	6	532.3	1	123.9		
2019 он	16	4,321.1				
2020 он	50	6,106.7	3	118.3	2	3,599.5
Дүн	88	15,134.8	4	242.2	2	3,599.5

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй 1А хорооллын дэд бүтцийг дуусаагүй барилгад 3,599.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргаа харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дуусаагүй барилгад 2017-2020 онд бүртгэлтэй 88 ТАХ-ний ажлын гүйцэтгэлийг холбогдох байгууллагуудтай тулгаж, бүртгэл, хадгалалт хамгаалалтын явцад хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн 2018-2020 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон ТАХ-ээс дараах ТАХ-үүдийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна. Тухайлбал:

- Дэнж багт ухаалаг худаг, 2018 он
- Оюуны спортын ордон, 2018 он
- Говил багийн Тахилтын худаг, 2019 он
- Эрдэнэ багийн 49-р гудамжны худаг, 2019 он
- Байцааны /505 тн/ зоорь, 2019 он
- Барилгачдын талбайн нийтийн бие засах газар, 2020 он
- Шүүхийн шинжилгээний албаны байр, 2020 он

Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын ажлууд нь ихэвчлэн дэд бүтцийн ажлууд байх бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хамтын ажиллагааны хүрээнд бүтээн байгуулж буй 1А хорооллын ИШС болон Эрдэнэт ШУТПарк ОНӨААТГ-ын үйлдвэрлэлийн барилга, багийн ӨЭМТөвөөс өөр томоохон бүтээн байгуулалтын ажил байхгүй байна.

Аймгийн төвийн томоохон сургууль, цэцэрлэгүүдийн хүүхдийн хамрагдалт, мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдал зэргээс үүдэн аймгийн хүн ам, эдийн засаг, нийгмийн орчны судалгаа, шинжилгээ хийж, хэрэгцээ, шаардлагыг

бодитой тооцож, үр дүнтэй, иргэдэд үр өгөөжөө өгөх бүтээн байгуулалтыг цогц байдлаар төлөвлөх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж буй ч төлөвлөлийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсаар байна.
- Төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэхгүй баталж байгаа нь хугацаандаа хэрэгжихгүй, он дамжих, чанаргүй гүйцэтгэх эрсдэл үүсгэж байна.
- Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаар худалдан авах ажиллагаа олон хоногоор хоцорч, үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлага үүссэн байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, өмнөх оны алдаа давтагдсаар байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын үр дүнг тооцоогүй байна.

Аудитаар нийт 5,502.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,033.8 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 1,468.8 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат-д

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар зураг төсөв, техникийн тодорхойлолт зэрэг төлөвлөлийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцүүлж буй эсэхийг хянаж, батлах.

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол шийдвэрлэлтийг хянаж, үнэлгээний хорооны гишүүдийн ур чадвар, үйл ажиллагааг сайжруулах.
- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулах, хангагдахгүй шалтгаан үр дагаврыг хэлэлцэн шийдвэрлэж, чанаргүй, дутуу гүйцэтгэдэг аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, холбогдох хяналтын байгууллагуудаар тодорхойлуулж, хариуцлага тооцох.

Аймгийн ОНӨГ-ын дарга Л.Оюунгэрэл-д

- ТЕЗ-ийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актыг үндэслэн ашиглагч байгууллагын хөрөнгөд шилжүүлэх.
- ХББЗА ОНӨААТҮГ-аас ирүүлж буй дуусаагүй барилгын жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ын хөрөнгө оруулалтын санхүүжилттэй тулгаж, тооцоо нийлсэн акт үйлдэж бүртгэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2021.06.22 № 027/247
танай 2021.06.17 -ны № 163 -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.


ЗАСАГ ДАРГАЙН
ОРЛОГЧ  М.ТҮМЭНЖАРГАЛ

В.Навзмаа-Г
Тайланг батсан
хүргүүлэх

8721020709

Саналд өгсөн тайлбар:

Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.